



ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ  
ХУВЬЦААТ КОМПАНИ

### ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 25 өдөр

Дугаар: 04/17

Улаанбаатар хот

#### Төлөвлөгөө батлах тухай

Сангийн сайдын 2017 оны 01 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.3.2 дахь заалт, Гүйцэтгэх захирлын 2016 оны 04/31 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн 2018 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллан, биелэлтийг 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор үе шаттай гарган танилцуулахыг газрын дарга нарт даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ



Г.ЭНХТАЙВАН

Гүйцэтгэх захирлын 2018 оны 03 дүгээр сарын 23-ны өдрийн 04 / 17 дугаар тушаалын Хавсралт



**“ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК-ИЙН 2018 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Хийж гүйцэтгэх ажлууд	Дүгнэх шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах нэгж, албан тушаалтан	Хяналт тавих албан тушаалтан	
0	1	2	3	4	5	
<b>1. Давхар даатгалын үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд:</b>						
1.	1.	МИД-ын борлуулалт эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах	Оролцогч даатгагч нартай “Алдагдал зогсоох давхар даатгалын гэрээ” байгуулсан байна.	1-2 дугаар сард	Андеррайтингийн газрын дарга Ерөнхий хуульч	Гүйцэтгэх захирал Дэд захирал
		Арилжааны банкттай байгуулах МИД-ын зуучлагчаар ажиллах гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж сунгагдсан байна.	1-2 дугаар сард	Андеррайтингийн газрын дарга Ерөнхий хуульч	Гүйцэтгэх захирал Дэд захирал	
		Оролцогч даатгагчдын МИД хариуцсан ажилтнууд, шинээр эрх авч буй даатгалын төлөөлөгчид, зуучлагч банкны эдийн засагч нар сургалтад хамрагдаж, МИД-ын талаар мэдлэгтэй болж, борлуулалт хийх чадвартай болсон байна.	1-5 дугаар сард	Андеррайтингийн газрын дарга, ажилтнууд	Дэд захирал	
		МИД-ын бүтээгдэхүүний эрсдэлийн үнэлгээ, давхар даатгалын хураамж болон оролцогчийн хураамжийн тооцооллыг борлуулалтын улирал эхлэхээс өмнө хийсэн байна.	1-2 дугаар сард	Андеррайтингийн газрын дарга Актуарч	Дэд захирал	
2.	2.	МИД-ын үйл ажиллагааг сайжруулах, идэвхжүүлэх,	Телевизийн нэвтрүүлэг хийх, зар сурталчилгаа түгээх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, гарын авлага, брошур ашиглан	1-7 дугаар сард	Андеррайтингийн газрын ажилтнууд Маркетингийн менежер	Дэд захирал

		борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх	сурталчлан таниулах зэрэг ажлуудын хийсэн байна.			
			Даатгалын төлөөлөгч, малчдад МИД-ын тухай мэдээллийг тогтмол хүргэж, сургалт зохион байгуулсан байна.	3-9 дүгээр сард	Андеррайтингийн газрын ажилтнууд	Дэд захирал
			МИД-ын борлуулалтын орлогыг 2.0 тэрбумд хүргэсэн байна.	2-7 дугаар сард	Андеррайтингийн газрын дарга, ажилтнууд	Гүйцэтгэх захирал Дэд захирал
			Манлай болон тэргүүний даатгалын төлөөлөгч нарыг шалгаруулж урамшуулна.	2-10 дугаар сард	Андеррайтингийн газрын дарга Даатгалын шинжээч	Гүйцэтгэх захирал
			Борлуулалтын хаалт хийж, холбогдох сангуудыг бүрдүүлсэн байна.	7-12 дугаар сард	Андеррайтингийн газрын дарга, ажилтнууд	Гүйцэтгэх захирал
			МИД-ын програм хангамжаас болон баталгаанаас илэрсэн алдаа, зөрчлийг тухай бүр засаж залруулсан байна.	2-9 дүгээр сард	Мэдээлэл технологийн ажилтан	Гүйцэтгэх захирал
3.	3.	Газар тариалангийн даатгалын үйл ажиллагааг сайжруулах, хэрэгжүүлэх	Тариалангийн индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүний бүтцийг тодорхойлсон байна, холбогдох судалгаануудыг хийх, загварчлалыг туршин судалсан байна.	1-9 дүгээр сард	Андеррайтингийн газрын дарга, ажилтнууд	Гүйцэтгэх захирал
			Тариалангийн уламжлалт даатгалын гэрээ, журмыг шинэчлэн батлуулж, давхар даатгалын гэрээг байгуулсан байна.	2-9 дүгээр сард	Андеррайтингийн газрын дарга Ерөнхий хуульч	Гүйцэтгэх захирал
			Тариалангийн даатгалын эрх зүйн орчин сайжирсан байна.	1-12 дугаар сард	Андеррайтингийн газрын дарга Ерөнхий хуульч	Гүйцэтгэх захирал
4.	4.	МИД болон бусад бүтээгдэхүүнийг олон улсын давхар даатгалд хамруулах	Олон улсын давхар даатгагчид МИД-ын дээд, дунд түвшний эрсдэлийг даатгуулсан байна.	4-6 дугаар сард	Андеррайтингийн газрын дарга Андеррайтер	Гүйцэтгэх захирал
			Газар тариалан болон бусад бүтээгдэхүүнийг олон улсын давхар даатгагчид даатгуулсан байна.	3-12 дугаар сард	Андеррайтингийн газрын дарга, ажилтнууд	Гүйцэтгэх захирал

**2.Зах зээлийн судалгаа хийж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргаж турших ажлын хүрээнд:**

5.	1.	Хөдөө аж ахуйн бусад салбарт шаардлагатай байгаа даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд үр дүнтэй нэвтрүүлэх	ХАА-н хүнд машин механизм, тоног төхөөрөмжийн даатгалын эрэлт хэрэгцээг судалж, даатгалын бүтээгдэхүүний талаар эрсдэлийн тооцоолол хийсэн байна.	2-5 дугаар сард	Бизнес хөгжил, төслийн газрын дарга, ажилтнууд	Гүйцэтгэх захирал
			Гахайн болон шувууны аж ахуйн давхар даатгалын олон улсын туршлага судалж, бүтээгдэхүүний ерөнхий танилцуулга боловсруулж, эрсдэлийн шинжилгээ хийсэн байна.	3-5 дугаар сард	Бизнес хөгжил, төслийн газрын дарга, ажилтнууд	Гүйцэтгэх захирал
			Шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэхэд шаардлагатай холбогдох гадаад, дотоодын байгууллагын төлөөлөлтэй уулзалт хийж, холбогдох материал, мэдээллийг цуглуулж, боловсруулсан байна.	5-12 дугаар сард	Бизнес хөгжил, төслийн газрын дарга, ажилтнууд	Гүйцэтгэх захирал
6.	2.	Үндэсний давхар даатгалын тогтолцоог нэвтрүүлэх	Олон улсын хууль эрх зүйн орчин, хууль тогтоомжийг харьцуулан судалж, шинэчлэн боловсруулсан байна.	1-12 дугаар сард	Бизнес хөгжил, төслийн газрын дарга, ажилтнууд Ерөнхий хуульч	Гүйцэтгэх захирал
			Эхний ээлжид хариуцах давхар даатгалын бүтээгдэхүүнүүдийн судалгаа, тооцоолол хийгдсэн байна.	1-12 дугаар сард	Бизнес хөгжил, төслийн газрын дарга, ажилтнууд Актуарч	Гүйцэтгэх захирал
			Хууль тогтоомжийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, түүнд ирүүлсэн саналуудыг нэгтгэж, Сангийн яаманд танилцуулж, УИХ-аар батлуулсан байна.	1-12 дугаар сард	Бизнес хөгжил, төслийн газрын дарга Ерөнхий хуульч	Гүйцэтгэх захирал
			Олон улсын давхар даатгалын корпорациудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлын эхлэл тавигдсан байна.	1-12 дугаар сард	Бизнес хөгжил, төслийн газрын дарга Гадаад хамтын ажиллагааны ажилтан	Гүйцэтгэх захирал
7.	3.	Компанийн үйл ажиллагаа болон давхар даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд сурталчлан таниулах	Хэвлэл мэдээллийн агентлаг, газруудаар дамжуулан компанийн үйл ажиллагааг сурталчлан, мэдээллийг олон нийтэд хүргэсэн байна.	1-12 дугаар сард	Маркетингийн менежер	Гүйцэтгэх захирал Дэд захирал
			МИД болон газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүний талаар нэвтрүүлэг, танилцуулга, шторк хийлгэн	1-12 дугаар сард	Маркетингийн менежер	Гүйцэтгэх захирал Дэд захирал

			хамтран ажилладаг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр түгээсэн байна.			
			Байгууллагын үйл ажиллагаа, даатгалын болон хөдөө аж ахуйн салбартай холбоотой мэдээ мэдээллийг цахим сайтад байрлуулж, компанийн фэйсбүүк хуудаст нийтэлсэн байна.	1-12 дугаар сард	Маркетингийн менежер Гадаад хамтын ажиллагааны ажилтан	Гүйцэтгэх захирал Дэд захирал
			Нийгмийн хариуцлагын хүрээнд компанийн ажилтнууд цусны төвд цусаа хандивлах, мод тарих, нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст туслах арга хэмжээнд оролцсон байна.	1-12 дугаар сард	Маркетингийн менежер Захиргаа, хүний нөөцийн ажилтан	Гүйцэтгэх захирал Дэд захирал
			Оролцогч талуудтай уулзалт, сургалт зохион байгуулсан байна.	1-12 дугаар сард	Маркетингийн менежер Гадаад хамтын ажиллагааны ажилтан	Гүйцэтгэх захирал Дэд захирал
8.	4.	Үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн төсөлд шаардлагатай заалтыг тусгуулахаар саналаа өгч ажиллах	Тариалангийн даатгалын тухай хуулийн төслийн ажлын хэсэгт орж хамтарч ажилласан байна.	1-12 дугаар сард	Бизнес хөгжил, төслийн газрын дарга Ерөнхий хуульч	Гүйцэтгэх захирал
			Шаардлагатай хууль, журмын төсөлд саналаа өгөх, шинээр боловсруулах ажлууд хийгдсэн байна.	1-12 дугаар сард	Бизнес хөгжил, төслийн газрын дарга Ерөнхий хуульч	
9.	5.	Компанийн бизнесийн стратеги, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах	Бизнес төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжүүлж ажилласан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлангаар гарган удирдлагад танилцуулсан байна.	1-12 дугаар сард	Бизнес хөгжил, төслийн газрын дарга, ажилтнууд	Гүйцэтгэх захирал
<b>3.Экспортын даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, хөгжүүлэх ажлын хүрээнд:</b>						
10.	1.	Экспортын даатгалтай холбоотой хууль, эрх	Холбогдох баримт бичгүүдийг боловсруулж, хууль эрх зүйн орчин сайжирсан байна.	1-12 дугаар сард	Экспортын даатгалын газрын дарга, ажилтнууд Зохицуулагч зөвлөх	Гүйцэтгэх захирал

		зүйн орчныг бүрдүүлэх, сайжруулах	Хууль эрх зүйн баримт бичиг, төслүүдэд олон улсын зөвлөхөөс зөвлөмж авч ажилласан байна.	1-12 дугаар сард	Дотоодын зөвлөх баг Экспортын даатгалын газрын дарга, ажилтнууд Зохицуулагч зөвлөх Дотоодын зөвлөх баг	Гүйцэтгэх захирал
11.	2	Олон улсын тэргүүлэгч байгууллагатай мастер гэрээ байгуулах	Мастер гэрээ болон ажлын даалгаврын төслийг олон улсын туршлагын дагуу Монгол Улсын нөхцөлд тохируулан боловсруулсан байна.	3-5 дугаар сард	Экспортын даатгалын газрын дарга, ажилтнууд Зохицуулагч зөвлөх Дотоодын зөвлөх баг	Гүйцэтгэх захирал
			Мастер гэрээ байгуулсан байгууллагатай хамтран сонгосон бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүлэхэд бэлэн болгосон байна.	7-12 дугаар сард	Экспортын даатгалын газрын дарга, ажилтнууд Зохицуулагч зөвлөх Дотоодын зөвлөх баг	Гүйцэтгэх захирал
12.	3.	Даатгуулагчдын шаардлага хэрэгцээнд нийцсэн экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулах	Даатгалын тухай хууль, дүрэм, журмын үнэлгээ хийгдэж, хууль, дүрэм, журам, гэрээний төсөл, үйл ажиллагааны үндсэн чиглэл боловсруулагдсан байна.	2-12 дугаар сард	Экспортын даатгалын газрын дарга, ажилтнууд Ерөнхий хуульч	Гүйцэтгэх захирал
			Экспортын зах зээлд тулгамдаж буй гол эрсдэлүүдийн талаар эрсдэлийн шинжилгээг хийж, эрсдэлийн удирдлагын техник үнэлгээний тайланг боловсруулсан байна.	9-11 дүгээр сард	Экспортын даатгалын газрын дарга, ажилтнууд Зохицуулагч зөвлөх Дотоодын зөвлөх баг	Гүйцэтгэх захирал
			5 жилийн бизнес төлөвлөгөөг боловсруулсан байна.	10-11 дүгээр сард	Экспортын даатгалын газрын дарга, ажилтнууд Зохицуулагч зөвлөх	Гүйцэтгэх захирал
			Сонгосон бүтээгдэхүүний үнэлгээний аргачлалыг тодорхойлж, актуар тооцоог хийсэн байна.	10-12 дугаар сард	Экспортын даатгалын газрын дарга, ажилтнууд Зохицуулагч зөвлөх Актуарч	Гүйцэтгэх захирал
13.	4.	Шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлэх үүднээс ажилтнуудын мэдлэг, чадавхыг хөгжүүлэх	Удирдлагын болон техникийн гол ажилтнуудыг гадаадын хамтран ажиллагч байгууллагуудаас туршлага судлах зорилгоор богино хугацааны сургалтад хамруулсан байна.	4-12 дугаар сард	Экспортын даатгалын газрын дарга, ажилтнууд Зохицуулагч зөвлөх	Гүйцэтгэх захирал
			Бүтээгдэхүүний хөгжил, борлуулалт хариуцсан ажилтнуудыг экспортын зээлийн	4-12 дугаар сард	Экспортын даатгалын газрын дарга, ажилтнууд	Гүйцэтгэх захирал

			даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулах, зах зээлд гаргах чиглэлээр мэргэшүүлэх 1-6 сарын сургалтад хамруулсан байна.		Зохицуулагч зөвлөх	
14.	5.	Олон улсын болон төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх	Хамтын ажиллагаа хөгжиж үр дүнгээ өгсөн байна.	1-12 дугаар сард	Экспортын даатгалын газрын дарга, ажилтнууд Зохицуулагч зөвлөх	Гүйцэтгэх захирал

**4. Компанийн хөрөнгө оруулалтын орлогыг нэмэгдүүлэх, сангийн хөрөнгийг зохион байгуулалтын ажлын хүрээнд:**

15.	1.	Дүрмийн сан, алдагдлаас хамгаалах сан, хамтын эрсдэлийн сан, дээд болон дунд түвшний эрсдэлийн сангуудын зохион байгуулалтыг хариуцах, холбогдох хууль, журмын дагуу хөрөнгө оруулалтад байршуулах	Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журам, шаардлагын дагуу хөрөнгө оруулалт хийгдэж бондын өгөөж, хадгаламжийн хүүгээр өсөж арвижсан байна.	1-12 дугаар сард	Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газрын дарга, ажилтнууд	Гүйцэтгэх захирал Дэд захирал
			МИД-ын дунд болон дээд түвшний эрсдэлээс хамгаалах санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар батлагдан, хэрэгжсэн байна.	1-6 дугаар сард	Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газрын дарга, ажилтнууд	Гүйцэтгэх захирал Дэд захирал
			МИД-ын 2018 оны болон дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангийн хураамжийг бүрэн төвлөрүүлсэн байна.	4-12 дугаар сард	Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газрын дарга, ажилтнууд	Гүйцэтгэх захирал Дэд захирал
16.	2.	МИД-ын болон газар тариалангийн даатгалын нөхөн төлбөрийн тооцооллыг хийх, олгох	МИД-ын болон Газар тариалангийн даатгалын нөхөн төлбөрийн журам шинэчлэн батлагдаж, хэрэгжсэн байна.	4-7 дугаар сард	Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газрын дарга, ажилтнууд Ерөнхий хуульч	Гүйцэтгэх захирал Дэд захирал
			МИД-ын нөхөн төлбөрийн тооцооллыг холбогдох гэрээ, журмын дагуу үнэн зөв тооцоолж, олгосон байна.	7-8 дугаар сард	Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газрын дарга, ажилтнууд Актуарч	Гүйцэтгэх захирал Дэд захирал

			Газар тариалангийн даатгалын нөхөн төлбөрийн тооцооллыг холбогдох гэрээ, журмын дагуу үнэн зөв тооцоолж, олгосон байна.	8-10 дугаар сард	Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газрын дарга, ажилтнууд Актуарч	Гүйцэтгэх захирал Дэд захирал
17.	3.	Компани өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх талаар зах зээлийн судалгаа хийх	Өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх талаар олон талт судалгааны ажил хийгдэж, судалгааны баримт бичиг боловсруулагдан, удирдлагад танилцуулагдсан байна.	1-12 дугаар сард	Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газрын дарга, ажилтнууд	Гүйцэтгэх захирал Дэд захирал

**5. Үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах дотоод ажлын хүрээнд:**

18.	1.	Компанийн хүний нөөц, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн асуудлыг шийдвэрлэх	Хүний нөөцийн бодлого, байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой асуудлыг тухай бүр Гүйцэтгэх удирдлагаар шийдвэрлүүлэн хэрэгжүүлсэн байна.	1-12 дугаар сард	Захиргаа, удирдлагын газрын дарга Захиргаа, хүний нөөцийн ажилтан	Гүйцэтгэх захирал Дэд захирал
			Бүтцийн өөрчлөлттэй холбогдуулан зарим ажилтны хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулсан байна.	1-3 дугаар сард	Захиргаа, удирдлагын газрын дарга Захиргаа, хүний нөөцийн ажилтан	Гүйцэтгэх захирал
			Бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор зарим ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт шинэчлэгдэн батлагдсан байна.	1-3 дугаар сард	Захиргаа, удирдлагын газрын дарга Ерөнхий хуульч Захиргаа, хүний нөөцийн ажилтан	Гүйцэтгэх захирал Дэд захирал
			Хөдөлмөрийн гэрээний хэрэгжилт ажилтан тус бүрээр дүгнэгдэн, ажлын үр дүнг харгалзан урамшуулал олгогдсон байна.	7, 12 дугаар сард	Газрын дарга нар Захиргаа, хүний нөөцийн ажилтан	Гүйцэтгэх захирал
			Олон нийтийн арга хэмжээний жилийн ажлын төлөвлөгөө батлагдан, бүрэн хэрэгжсэн байна.	1-12 дугаар сард	Захиргаа, удирдлагын газрын дарга Захиргаа, хүний нөөцийн ажилтан	Дэд захирал
			Дотоод сургалтын төлөвлөгөө батлагдан хэрэгжсэн байна.	3-12 дугаар сард	Захиргаа, удирдлагын газрын дарга	Дэд захирал

					Захиргаа, хүний нөөцийн ажилтан	
19.	2.	Санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, хяналт тавих, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргах, нэгтгэх, тайлагнах	Санхүүгийн болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө бодитойгоор төлөвлөгдсөн байна.	1, 11 дүгээр сард	Газрын дарга нар Ерөнхий нягтлан бодогч	Гүйцэтгэх захирал Дэд захирал
			Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой хууль, журам, бодлогын баримт бичгүүд бүрэн хэрэгжсэн байна.	1-12 дугаар сард	Захиргаа, удирдлагын газрын дарга Ерөнхий нягтлан бодогч	Гүйцэтгэх захирал
			Санхүүгийн жил, улирлын тайлан хугацаандаа үнэн зөв гарч, холбогдох газруудад хүргэгдэн шаардлагатай үнэлгээг авсан байна.	1, 2, 4, 7, 10 дугаар сард	Захиргаа, удирдлагын газрын дарга Ерөнхий нягтлан бодогч	Гүйцэтгэх захирал
			Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	1-12 дугаар сард	Захиргаа, удирдлагын газрын дарга Нягтлан бодогч	Гүйцэтгэх захирал
20.	3.	Компанийн худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанууд хууль, журмын дагуу хэрэгжсэн байна.	1-12 дугаар сард	Захиргаа, удирдлагын газрын дарга Захиргаа, аж ахуй хариуцсан ажилтан	Гүйцэтгэх захирал
			Худалдан авах үйл ажиллагаанд цахим худалдан авах ажиллагааны системийг нэвтрүүлсэн байна.	1-12 дугаар сард	Захиргаа, удирдлагын газрын дарга Захиргаа, аж ахуй хариуцсан ажилтан	Гүйцэтгэх захирал
			Оффисын байр, техник хэрэгсэл, эд хөрөнгийн хангамж, бүртгэл, хадгалалт хамгаалалт шаардлагатай түвшинд хүрсэн байна.	1-12 дугаар сард	Захиргаа, удирдлагын газрын дарга, ажилтнууд	Гүйцэтгэх захирал Дэд захирал
21.	4.	Компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах	Газар нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирсан байна. Албан бичиг хэргийн хөтлөлт, хадгалалт журам, зааврын дагуу явагдсан байна.	1-12 дугаар сард	Захиргаа, удирдлагын газрын дарга Архив, бичиг хэргийн ажилтан	Гүйцэтгэх захирал Дэд захирал
			Жилийн ажлын төлөвлөгөө сар улирлаар батлагдан хэрэгжсэн байна. Компанийн жил, улирлын үйл ажиллагааны	1, 4, 7, 10, 12 дугаар сард	Захиргаа, удирдлагын газрын дарга Захиргаа, хүний нөөцийн	Гүйцэтгэх захирал Дэд захирал

		тайланг газар нэгж бүрээр гарган нэгтгэж гүйцэтгэх удирдлагад танилцуулсан байна.		ажилтан	
		Ажилтнууд ажиллах хэвийн нөхцөлөөр бүрэн хангагдсан байна.	1-12 дугаар сард	Захиргаа, удирдлагын газрын дарга, ажилтнууд	Гүйцэтгэх захирал

**6. Хуулийн хэрэгжилт, авлигаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд**

22.	1.	Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлэх гарган	Төлөвлөгөөнд заасан ажлыг гүйцэтгэж Авлигатай тэмцэх газрын даргын тушаалаар батлагдсан аргачлалын дагуу дүгнүүлж шаардлагатай оноог авсан байна. Албан тушаалтнуудаас ХАСХОМ-ийг Авлигатай тэмцэх хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах тухай хуульд заасны дагуу бүрэн авсан байна.	12-р сарын 25-ны өдрийн дотор 2-р сарын 15-ны өдрийн дотор	Ерөнхий хуульч Захиргаа, удирдлагын газрын дарга Ерөнхий хуульч	Гүйцэтгэх захирал Сангийн яамны эрх бүхий албан тушаалтан
23.	2.	Компанийн үйл ажиллагааны эрх зүйн үндэслэлийг ханган ажиллах	Компанийн үйл ажиллагаатай холбоотой хууль, журам, дүрмийн хэрэгжилт сайн байна. Шаардлагатай хууль, журам, дүрмийн төсөл боловсруулагдан өргөн баригдсан байна.	1-12 дугаар сард	Ерөнхий хуульч Газрын дарга нар	Гүйцэтгэх захирал Дэд захирал

**7. Компанийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх, Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод ажлын хүрээнд**

24.	1.	Хөндлөнгийн аудит, хяналт шинжилгээний байгууллагаас хийсэн шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлэх, илрүүлсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг авч ажиллах	Зөвлөмжийг хэрэгжүүлэх, зөрчил дутагдлыг арилгах ажлын төлөвлөгөө гарган бүрэн хэрэгжүүлсэн байна.	1-12 дугаар сард	Дотоод хяналтын ажилтан Газрын дарга нар Ерөнхий нягтлан бодогч	Аудитын хорооны дарга Гүйцэтгэх захирал
25.	2.	Компанийн төсөв,	Компанийн санхүү, төсөв, хөрөнгийн	4, 7 дугаар	Дотоод хяналтын ажилтан	Аудитын

		санхүү, хөрөнгө оруулалт зэрэгт дотоод аудитыг хийх	удирдлага, хөрөнгө оруулалтад дотоод аудит хийж, зөвлөмж гаргах, биелэлтэд хяналт тавигдсан байна.	сард		хорооны дарга
26.	3.	Хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын үйл ажиллагааг зохион байгуулах, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах	Хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөлийн аливаа үйл ажиллагаа, шийдвэр Компанийн тухай хууль, холбогдох бусад дүрэм, журамд бүрэн нийцсэн байна. Шийдвэрүүд бүрэн хэрэгжсэн байна.	1-12 дугаар сард	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга  Ерөнхий хуульч	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

----- о о о -----